



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 06 сарын 26 өдөр

Дугаар A/53

Улаанбаатар хот

┌ Сургалт зохион байгуулах тухай ┐


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолоор баталсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 3.3.1, 3.3.4 дэх заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 19/16 дугаар тогтоолоор баталсан Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1.54 дэх заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэрүүлэгчдийн нарийн бичгийн даргын 2019 оны A/27 дугаар тушаал, тус газрын дүрмийн 2.5.3, 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Гадаад, дотоодын иргэд, жуулчдын аюулгүй байдлыг хангах, бүх нийтийн хууль эрх зүйн анхан шатны мэдлэг олгох зорилгоор “Хөтөч, тайлбарлагчдын ур чадвар, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх нь” сэдэвт сургалтыг 2019 оны 05 дугаар сарын 11, 12-ны өдрүүдэд зохион байгуулахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс /В.Батчимэг/-т даалгасугай.

2.Сургалт зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, зарцуулах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Сургалтын төсөв болох 6.220.000 /зургаан сая хоёр зуун хорин хоёр мянга/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг нягтлан бодогч /Б.Батцоож/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА D. Balsin Д. БАТСҮХ



• 1150500257

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2019 оны 06
сарын 26 өдрийн А/53 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

5284325 СБТ-8936 1118260502

**“ХӨТӨЧ, ТАЙЛБАРЛАГЧДЫН УР ЧАДВАР, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН
МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ” СЭДЭВТ СУРГАЛТЫН УДИРДАМЖ**

2019 оны 06-р сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

НЭГ. ЗОРИЛГО

Аялал жуулчлалын зочлох үйлчилгээний салбарынханд тэр дундаас аялал жуулчлалын хөтөч, тайлбарлагч нарт Улаанбаатар хотыг эерэгээр, зөв тайлбарлах, гадаад, дотоодын жуулчны аюулгүй байдлыг хангах, хууль эрх зүйн анхан шатны мэдлэг, мэдээлэл олгоход тус сургалтын зорилго оршиж байна.

ХОЁР. ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

- Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
- Нийслэлийн Аялал жуулчлалын газар

ГУРАВ. ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

- Мэргэжлийн хөтөч, тайлбарлагчдын холбоо
- Монголын аялал жуулчлалын холбоо

ДӨРӨВ. СУРГАЛТЫН ХУГАЦАА

2019 оны 05-р сарын 11, 12-ны өдөр

ТАВ. ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

“Holiday inn” зочид буудалд зохион байгуулагдана

ЗУРГАА. СУРГАЛТАД ХАМРАГДАХ БАЙГУУЛЛАГУУД

Аялал жуулчлалын тур оператор компаниудын мэргэжлийн хөтөч, тайлбарлагчид оролцоно.

ДОЛОО. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Хугацаа	Сэдэв	Хариуцах эзэн	Болох газар
2019 оны 05-р сарын 11-ний өдөр			
09.30-09.50	Бүртгэл	-Нийслэлийн Аялал жуулчлалын газар -Мэргэжлийн хөтөч, тайлбарлагчдын холбоо	
09.50-10.00	Нээлтийн үйл ажиллагаа	- НЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс -Нийслэлийн Аялал жуулчлалын газар -Мэргэжлийн хөтөч, тайлбарлагчдын холбоо	"Holiday inn" зочид буудлын "Meeting room" танхимд
10.00-11.00	Тайлбарыг хэрхэн бэлдэх, матрекс загвар	Мэргэжлийн хөтөч, тайлбарлагчдын холбоо	
11.00-12.00	Хотын автобустай болон явган аяллын онол, арга зүй	Мэргэжлийн хөтөч, тайлбарлагчдын холбоо	
12.00-13.00	Үдийн хоол /"Holiday inn" зочид буудлын 2-р давхар/		
13.00-14.30	Улаанбаатар хотын түүх, соёл, уламжлал	Улаанбаатар хотын музейн эрдэм шинжилгээний ажилтан	"Holiday inn"
14.30-15.00	Гадаад, дотоодын иргэд, жуулчдыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь	Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл	зочид буудлын "Meeting room" танхимд
15.00-15.15	Завсарлага /"Holiday inn" зочид буудалд/		
15.15-16.15	Хөтөч, тайлбарлагч		

	нарын хотын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл	-Нийслэлийн Аялал жуулчлалын газар -Луврын музейн куратор	"Holiday inn"
16.15-17.30	Хөтөч, тайлбарлагчдын соёл, ёс зүй, олон улсын стандарт	Г.Оюунтунгалаг	зочид буудлын "Meeting room" танхимд
17.30-18.00	Маргаашийн хичээлийн зааварчилгаа, группуудыг хуваарилах	-Нийслэлийн Аялал жуулчлалын газар -Мэргэжлийн хөтөч, тайлбарлагчдын холбоо	
2019 оны 05-р сарын 12-ны өдөр			
10.00-12.00	Жуулчдын аюулгүй байдлыг хангах, хууль эрх зүй орчин	-НЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс -Нийслэлийн Цагдаагийн газар	"Holiday inn" зочид буудлын "Meeting room" танхимд
12.00-13.30	Үдийн хоол /"Holiday inn" зочид буудлын 2-р давхар/		
13.30-15.30	Автобустай аяллын дадлага /1-р ээлж/	-Нийслэлийн Аялал жуулчлалын газар	-“Сити тур” болон явган аяллыг
13.30-15.30	Улаанбаатар хотын явган аяллын дадлага /1-р ээлж/	-Мэргэжлийн хөтөч, тайлбарлагчдын холбоо /Тусгай хөтөлбөөр/	МХТХ-ны багш нар удирдан явуулна
15.30-17.30	Автобустай аяллын дадлага /2-р ээлж/	-Нийслэлийн Аялал жуулчлалын газар	-“Сити тур”болон явган аяллыг

15.30-17.30	Улаанбаатар хотын явган аяллын дадлага /2-р ээлж/	-Мэргэжлийн хөтөч, тайлбарлагчдын холбоо /Тусгай хөтөлбөрөөр/	МХТХ-ны багш нар удирдан явуулна
17.30-18.00	“Holiday inn” зочид буудалд ирсэн байна /Завсарлага/		
18.00-18.30	Хаалтын ажиллагаа, батламж гардуулна	-НЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс -Нийслэлийн Аялал жуучлалын газар -Мэргэжлийн хөтөч, тайлбарлагчдын холбоо	“Holiday inn” зочид буудлын “Meeting room” танхимд

НАЙМ СУРГАЛТЫН ҮР ДҮН

Улаанбаатар хотын аяллын хөтөч, тайлбарлагчдын ур чадвар, хууль эрх зүйн мэдлэг, хариуцлагын тогтолцоо сайжирч, жуулчны аюулгүй байдал хангагдана.

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2019 оны 06
сарын 26 өдрийн А/53 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

**“ХӨТӨЧ, ТАЙЛБАРЛАГЧДЫН УР ЧАДВАР, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН
МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ” СУРГАЛТЫН ТӨСӨВ**

д/д	Сургалт зохион байгуулах зардал	Тоо/ Хугацаа	Үнэ (төг)	Нийт үнэ
1	Өдрийн хоол	96* 2 өдөр	10 000	1 920 000
2	Цайны завсарлагааны жигнэмэг, цай, кофены зардал	96* 2 өдөр	5000	960,000
3	Сургалтын танхимын төлбөр	10 цаг	172,800	1,728,000
4	Оролцогч нарт олгох батламж	80 хүн	1000	80 000
5	Багш нарын төлбөр /Улаанбаатар хотын музей тайлбарлагчид/	2 хүн	66 000	132 000
6	Багш нарын төлбөр /Танхимын хичээл заах багш нар/	2 хүн	110 000	220 000
		2 хүн	50 000	100 000
7	Явган аяллын дадлага хийх багш нарын төлбөр	6 хүн /1 багш нийт 4 цаг/	110 000	660 000
8	Автобустай аяллын дадлага хийх багш нарын төлбөр	2 хүн /1 багш нийт 4 цаг/	110 000	220 000
9	Автобусны зардал, анонс хэвлүүлэх	багц	200 000	200 000
	Нийт дүн			6 220 000